



“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2021.01.14 № 02/171
танай _____-ны № _____-т

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах
тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар “2021 оныг техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 тоот тушаалын удирдамжийн дагуу боловсруулан ирүүлэх;

2. “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр” болон 2021 оныг техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил болгон зарласантай холбогдуулан тухайн салбарт хийгдэх цахим үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх төлөвлөгөөг ирүүлнэ үү.

Хавсралт: 3. хуудастай.

ДЭД САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ





**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01.


Улаанбаатар хот

2021 оныг “Техник, технологийн
шинэчлэлт-цахим шилжилтийн
жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2021 оныг “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласугай.
2. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан зам, тээврийн салбарт дэвшилтэт шинэ техник, технологийг судалж нэвтрүүлэх, салбарт хийгдэж буй цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нар, харьяа байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.
4. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан, биелэлтийг улирал тутамд танилцуулж ажиллахыг Дэд сайд Ж.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.
5. Өнэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай

САЙД  Л.ХАЛТАР



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2021 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн
Ард дүгээр тушаалын хавсралт



“ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ-ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго:

Зам, тээврийн салбарт дэвшилтэт, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, салбарт хийгдэж байгаа цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор зарлаж байгаа “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд яам, харьяа байгууллага, салбарын чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаачид, инженер, техникийн ажилтнуудын хийх ажлын чиглэлийг тодорхойлоход уг удирдамжийн зорилго оршино.

Хугацаа:

“Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийх ажлуудыг 2021 онд багтаан хэрэгжүүлэх бөгөөд цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг тогтмолжуулан байнга хийхээр төлөвлөнө.

Хамрах хүрээ:

Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллага, салбарын чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаачид, инженер, техникийн ажилтнууд

Хийх ажлын чиглэл:

- Зам, тээврийн салбарт олон улсын стандартад нийцсэн, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан, орчин үеийн дэвшилтэт, шинэ техник, технологийг нэвтрүүлэх;
- Зам, тээврийн салбарт цахим шилжилт хийх ажлыг эрчимжүүлэх;
- Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах;
- Зам, тээврийн салбарт дэвшилтэт, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх бодлого, зорилго, зорилтыг шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа салбарын бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэх;
- Салбарын байгууллагуудын чадавхыг бэхжүүлж, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах;
- “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;
- “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- “Улаанбаатар төмөр замын цахим шилжилт-2025” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцан гүйцэтгэх үүрэг:

1. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийх ажлын явцыг зохицуулж, удирдамжаар хангах, хяналт тавих;
2. Зам, тээврийн салбарын хэмжээнд “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэн байгууллага, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаачид, инженер техникийн ажилтнуудыг татан оролцуулах, үр дүнг нь үнэлэх хүрэх асуудлаар цаг тухайд нь шийдвэр гаргах;
3. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийгдэх ажил, санал санаачлагыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг тухай бүрд нь шийдвэрлэх;
4. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийсэн ажлыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах
5. Дэвшилтэй, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилт хийх ажлыг эрчимжүүлэх талаар тодорхой үр дүн гаргаж, сайн ажилласан албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг шалгаруулан шагнаж урамшуулах;

Харьяа байгууллага, салбарын чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүрэг, оролцоо:

1. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийг дэмжиж, тус тусын байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах;
2. Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд тус тусын байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, салбарт тодорхой ахиц дэвшил гаргах, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг тогтмолжуулах;
3. Өөрийн байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжээнд “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл боломжийг ханган, жилийн хугацаанд хийсэн ажлуудыг шалгаруулж урамшуулах;
4. Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийн хүрээнд хийсэн ажлыг олон нийтэд сурталчлах, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, явц, байдлын талаар Зам, тээврийн хөгжлийн яаманд мэдээлж байх;

Эрдэмтэн, судлаачид, инженер, техникийн ажилтнуудын оролцоог хангах:

1. “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил”-ийг дэмжиж, идэвхи, санаачлага гарган ажиллах нөхцөл боломж, мэдээллээр хангах;
2. Жилийн ажлын хүрээнд хийсэн судалгааны ажлын үр дүн, санал, санаачлага, зочинтой цагвар, шийдлийг салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар холбогдох байгууллага, баг хамт олны ирүүлсэн санал санаачлагыг дэмжиж, үр дүнтэй хамтран ажиллах

-оОо-

